

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **САГ-2026/23/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	13
3.4.2 Авлага .....	14
3.4.3 Урьдчилгаа.....	15
3.4.4 Бараа материал.....	16
3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө.....	17
3.4.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	17
3.4.7 Үндсэн хөрөнгө .....	18
3.4.8 Өр төлбөр.....	19
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо .....	20
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	21
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	21
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	22
3.5.3 Нэмэлт төсөв .....	23
3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл.....	24
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт .....	24
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	28
4.1 Ерөнхий зүйл .....	28
4.2 Материаллаг байдал .....	28
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	28
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	28
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	28
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	29
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	29
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	30
5.1 Харьяа байгууллагууд .....	30
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч .....	30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	33
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	33
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	33
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	34

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БННБС	Барилгын норм норматив боловсруулах сан
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖ	Байгаль орчин, аялал жуулчлал
БХТ	Барилгын хөгжлийн төв
БХБ	Барилга, хот байгуулалт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХББОС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт
ХОИЗД	Хөрөнгө оруулалт, их засварын данс
ХСУХАТАҮЗХ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
САЙД Э.БАТ-АМГАЛАН ТАНАА

2026.04.27 № 1142  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 549,512.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Харьяа 3 байгууллага харилцагч байгууллагуудтай 37,680.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл, 57,801.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Барилгын норм норматив боловсруулах сангаас чиг үүргийн бус ажилд 6.8 сая төгрөгийн дотоод албан томилот, байгууллагын ажилтан биш хүмүүст 63.9 сая төгрөгийн гадаад албан томилот олгосон, харьяа 2 байгууллага сургалт зохион байгуулах болон үзэсгэлэнд оролцохоор 134.3 сая төгрөгийг аяллын компанид шилжүүлсэн;

- 20 минут хот хөгжлийн төв бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад 121.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон;
- Харьяа 1 байгууллага нээлттэй тендер сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй, шууд гэрээ байгуулж 5,135.6 сая төгрөгийн худалдан авалт, мөн гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 5,980.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, үнэлгээний хороо тендерийг үнэлэхдээ 18 хоногийн дараа хуралдаж үнэлгээний шаардлага хангаагүй 5,311.7 сая төгрөгийн оролцогчийг шалгаруулсан байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 10 дугаар зүйлийн 10.1.11, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.2.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

“Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-ийн хүрээнд орон нутагт мэргэжлээрээ ажиллаж, амьдрах төрийн албан хаагчдад зориулсан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, ногоон барилгын шаардлагыг хангасан орон сууцны загвар зураг төслүүдийг боловсруулан, хэсэгчилсэн шийдлээр төлөвлөн, 2024–2025 онд аймаг, сумдын Засаг дарга нартай хамтран 12 байршилд хэрэгжүүлж, 12 барилгын зураг төсөл, магадлалын дүгнэлтээр баталгаажсан бөгөөд цаашид 8 болон 15 айлын орон сууцны иж бүрэн зураг төслийг Ногоон барилгын үнэлгээний BESTGER аргачлалын шаардлагад нийцүүлэн боловсруулж, ногоон, тогтвортой хөгжлийн шалгуураар баталгаажсан зураг төсөлтэй болох чиглэлээр ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа “Солонго 1”, “Солонго 2” төслийн хүрээнд 35 блок, “Эко Яармаг 1” төслийн хүрээнд 4 блок барилгын угсралтын ажлыг хийж, “Залуус 1” төслийн эхний ээлжийн шугам сүлжээний угсралтын ажил 90.0 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус яам нь 2023-2025 онд 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй ипотекийн зээл авсан нийт 5173 өрхийн 8,025.6 сая төгрөгийн хүүгийн татаас, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан хүүгийн өгөөж болон хөрөнгө оруулалтын өгөөжийн зөрүү 35,471.9 сая төгрөг, нийт 43,497.5 сая төгрөгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны урсгал зардал дээр төлөвлөн баталж, Монгол банк болон Сангийн яамны хоорондын тооцоог үндэслэн Монгол банканд шилжүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монгол улсын хэмжээнд 155 иргэн, 870 аж ахуйн нэгж, байгууллагын 1025 барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулсан бөгөөд хяналт шалгалтаар нийт 4595 зөрчил илрүүлснээс 2552 зөрчлийг бүрэн арилгуулснаар зөвлөмжийн хэрэгжилт 55.5

хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Мөн нийт 731,550.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 60 барилга байгууламж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүрэн зогсоон, эрх бүхий албан тушаалтанд албан даалгавар өгч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ байгуулж 30 хувийн урьдчилгаа төлбөрөө төлж дуусгасан, иргэд гэрээний үүргээ биелүүлсэн боловч, үлдэгдэл төлбөрөө төлж орон сууцаа өмчилж авах эрх зүйн байдал нь бүрдээгүй тул “Төрийн өмчийн орон сууцыг иргэнд хөлслүүлэх, өмчлүүлэх, борлуулах журам” батлуулахаар Засгийн газарт хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



СМ

С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2024 оны	2025 оны
	12-р сарын 31	12-р сарын 31
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,626,770,648.0</b>	<b>1,868,529,896.6</b>
Мөнгөн хөрөнгө	116,093,075.2	82,270,569.9
Авллага	77,713,326.1	89,469,611.8
Урьдчилгаа	5,245,682.7	3,406,845.4
Бараа материал	64,199,034.2	60,628,668.5
Бусад эргэлтийн хөрөнгө	1,363,519,529.8	1,632,754,201.0
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>326,642,345.8</b>	<b>321,392,298.4</b>
Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,111,309.1	3,130,451.4
Үндсэн хөрөнгө	323,531,036.7	318,261,847.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,953,412,993.8</b>	<b>2,189,922,195.0</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>796,705,107.7</b>	<b>790,119,080.7</b>
Богино хугацаат өр төлбөр	237,908,686.5	226,617,881.2
Урт хугацаат өр төлбөр	558,796,421.2	563,501,199.5
<b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,156,707,886.1</b>	<b>1,399,803,114.3</b>
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,953,412,993.8</b>	<b>2,189,922,195.0</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2024 оны	2025 оны
	12-р сарын 31	12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>490,614,338.6</b>	<b>373,204,499.8</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,709,545.3	373,204,499.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,904,793.3	0.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>75,848,035.5</b>	<b>114,519,455.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,848,035.5</b>	<b>114,519,455.7</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,422,606.4	69,564,391.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,601,615.4	7,101,867.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	696,953.0	1,159,279.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,604.4	381,529.7
Хангамж, бараа материалын зардал	170,584.5	172,904.7
Нормативт зардал	3,996.1	3,576.7
Эд хогшил, урсгал засварын зардал	327,917.4	123,201.9
Томилолт, зочны зардал	316,060.3	218,136.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,014,225.0	58,603,171.6
Бараа үйлчилгээний бусад зардал	8,030,650.3	1,800,722.3
ТАТААС	0.0	43,497,491.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,425,429.1	1,457,573.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>414,766,303.1</b>	<b>258,685,044.1</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,659.0	2,857.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,887,336.9	4,576,991.7
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>386,885,625.2</b>	<b>254,110,910.0</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>642,894,296.7</b>	<b>0.0</b>	<b>642,894,296.7</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(17,088,106.6)	0.0	(17,088,106.6)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>625,806,190.1</b>	<b>0.0</b>	<b>625,806,190.1</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	6,076,750.5	0.0	6,076,750.5
Өмчид гарсан өөрчлөлт	138,319,057.0	0.0	138,319,057.0
Зарласан ногдол ашиг	(379,736.7)	0.0	(379,736.7)
Тайлант үеийн үр дүн	386,885,625.2	0.0	386,885,625.2
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,156,707,886.1</b>	<b>0.0</b>	<b>1,156,707,886.1</b>
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,156,707,886.1</b>	<b>0.0</b>	<b>1,156,707,886.1</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(9,083,452.6)	0.0	(9,083,452.6)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,147,624,433.5</b>	<b>0.0</b>	<b>1,147,624,433.5</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	30,000.0	0.0	30,000.0
Зарласан ногдол ашиг	(1,962,229.2)	0.0	(1,962,229.2)
Тайлант үеийн үр дүн	254,110,910.0	0.0	254,110,910.0
<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>1,399,803,114.3</b>	<b>0.0</b>	<b>1,399,803,114.3</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2024 оны	2025 оны
	12-р сарын 31	12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>548,955,001.6</b>	<b>467,982,475.7</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,964,086.3	467,982,475.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,990,915.3	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>164,548,437.4</b>	<b>289,873,554.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>164,548,437.4</b>	<b>289,873,554.5</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,220,289.2	178,390,504.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,262,844.2	41,602,762.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,733,829.7	13,350,108.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,210,454.1	14,381,075.8
Хангамж, бараа материалын зардал	27,836,520.2	38,454,665.4
Эд хогшил, урсгал засварын зардал	521,765.1	128,454.4
Томиллолт, зочны зардал	302,413.5	218,136.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,487,129.4	46,874,045.7
Бараа үйлчилгээний бусад зардал	29,865,333.0	23,381,254.8
ТАТААС	0.0	43,497,491.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,328,148.2	67,985,558.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>384,406,564.2</b>	<b>178,108,921.2</b>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,483,336.8	3,664,440.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	350,061,651.0	215,642,027.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	350,061,651.0	215,642,027.3
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(347,578,314.2)</b>	<b>(211,977,586.8)</b>
БУСАД ЭХ ҮҮСВЭР	28,744.0	132,629.3
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	68,938.1	86,468.9
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(40,194.1)</b>	<b>46,160.4</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>36,788,055.9</b>	<b>(33,822,505.2)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79,305,019.3	116,093,075.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116,093,075.2	82,270,569.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>410,961,448,300.00</b>	<b>271,477,814,086.36</b>	139,483,634,213.64	66.1
Татварын бус орлого	410,961,448,300.00	271,477,814,086.36	139,483,634,213.64	66.1
Тусламжийн орлого	410,961,448,300.00	271,477,814,086.36	139,483,634,213.64	66.1
Улсын төсвөөс санхүүжих	410,961,448,300.00	271,477,814,086.36	139,483,634,213.64	66.1
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>410,961,448,300.00</b>	<b>271,477,814,086.36</b>	139,483,634,213.64	66.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,689,048,300.00</b>	<b>51,245,779,428.00</b>	20,443,268,872.00	71.5
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,183,486,300.00</b>	<b>7,162,377,561.65</b>	1,021,108,738.35	87.5
<b>Цалин хөлс, нэмэгдэл урамшил</b>	<b>5,920,002,300.00</b>	<b>5,446,799,509.17</b>	473,202,790.83	92.0
Үндсэн цалин	4,155,740,100.00	3,661,641,766.40	494,098,333.60	88.1
Нэмэгдэл	938,788,900.00	796,331,269.65	142,457,630.35	84.8
Унаа хоолны хөнгөлөлт	434,153,700.00	613,449,021.95	(179,295,321.95)	141.3
Урамшуулал	391,319,600.00	375,377,451.17	15,942,148.83	95.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>774,188,900.00</b>	<b>694,757,027.50</b>	79,431,872.50	89.7
Тэтгэврийн даатгал	526,209,100.00	470,255,116.04	55,953,983.96	89.4
Тэтгэмжийн даатгал	61,967,500.00	56,696,005.97	5,271,494.03	91.5
ҮОМШӨ-ний даатгал	31,390,100.00	30,819,395.39	570,704.61	98.2
Ажилгүйдлийн даатгал	30,907,400.00	27,648,093.97	3,259,306.03	89.5
Эрүүл мэндийн даатгал	123,714,800.00	109,338,416.13	14,376,383.87	88.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>279,813,600.00</b>	<b>251,376,532.00</b>	28,437,068.00	89.8
Гэрэл, цахилгаан	5,383,300.00	2,644,159.00	2,739,141.00	49.1
Байрны түрээс	274,430,300.00	248,732,373.00	25,697,927.00	90.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>155,786,500.00</b>	<b>127,022,748.98</b>	28,763,751.02	81.5
Бичиг хэрэг	35,618,900.00	30,328,050.00	5,290,850.00	85.1
Тээвэр, шатахуун	15,007,300.00	14,861,888.00	145,412.00	99.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,056,500.00	37,224,765.98	3,831,734.02	90.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	887,300.00	0.00	887,300.00	0.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,216,500.00	44,608,045.00	18,608,455.00	70.6
<b>Нормативт зардал</b>	<b>1,125,000.00</b>	<b>0.00</b>	1,125,000.00	0.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,125,000.00	0.00	1,125,000.00	0.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>118,045,700.00</b>	<b>116,085,690.00</b>	1,960,010.00	98.3
Багаж, техник, хэрэгсэл	24,098,400.00	24,098,350.00	50.00	100.0
Урсгал засвар	93,947,300.00	91,987,340.00	1,959,960.00	97.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>89,946,200.00</b>	<b>65,661,925.00</b>	24,284,275.00	73.0
Гадаад албан томилолт	5,648,300.00	5,647,540.00	760.00	100.0
Дотоод албан томилолт	84,297,900.00	60,014,385.00	24,283,515.00	71.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>781,757,700.00</b>	<b>398,842,020.00</b>	382,915,680.00	51.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	694,318,300.00	382,771,549.00	311,546,751.00	55.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,479,000.00	0.00	4,479,000.00	0.0
Даатгалын үйлчилгээ	5,689,700.00	0.00	5,689,700.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,227,400.00	0.00	1,227,400.00	0.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	146,900.00	0.00	146,900.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,468,500.00	2,249,000.00	47,219,500.00	4.5
Газрын төлбөр	3,095,000.00	988,951.00	2,106,049.00	32.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,332,900.00	12,832,520.00	10,500,380.00	55.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,820,400.00</b>	<b>61,832,109.00</b>	988,291.00	98.4
Бараа үйлчилгээний бусад зардал	56,874,500.00	55,886,209.00	988,291.00	98.3

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,945,900.00	5,945,900.00	0.00	100.0
<b>ТАТААС</b>	<b>62,861,404,500.00</b>	<b>43,497,491,653.74</b>	19,363,912,846.26	69.2
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>62,861,404,500.00</b>	<b>43,497,491,653.74</b>	19,363,912,846.26	69.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,861,404,500.00	43,497,491,653.74	19,363,912,846.26	69.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>644,157,500.00</b>	<b>585,910,212.61</b>	58,247,287.39	91.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>644,157,500.00</b>	<b>585,910,212.61</b>	58,247,287.39	91.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	212,271,000.00	211,258,000.00	1,013,000.00	99.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	314,840,500.00	304,000,000.00	10,840,500.00	96.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	117,046,000.00	70,652,212.61	46,393,787.39	60.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>334,772,400,000.00</b>	<b>215,732,034,658.36</b>	119,040,365,341.64	64.4
Барилга байгууламж	315,549,800,000.00	197,719,209,278.36	117,830,590,721.64	62.7
Их засвар	5,068,700,000.00	4,842,986,103.00	225,713,897.00	95.5
Тоног төхөөрөмж	14,153,900,000.00	13,169,839,277.00	984,060,723.00	93.0
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>4,500,000,000.00</b>	<b>4,500,000,000.00</b>	0.00	100.0
Эргэж төлөгдөх зээл	4,500,000,000.00	4,500,000,000.00	0.00	100.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	0	100.0
Төсвийн байгууллага	2	2	0	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>122</b>	<b>114</b>	8	93.4
Удирдах ажилтан	21	21	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	101	93	8	92.1
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>122</b>	<b>114</b>	8	93.4
Төрийн захиргааны албан хаагч	111	104	7	93.7
Ажлын албаны албан хаагч	3	3	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	4	5	(1)	125.0
Улс төрийн албан хаагч	2	2	0	100.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн	2	0	2	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>Тусламжийн орлого</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>Хандив тусламж /дотоод/</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>1,044,880,835.86</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		172,847,715.36
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		872,033,120.50
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,044,880,835.86</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>172,847,715.36</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		172,847,715.36
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>872,033,120.50</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		872,033,120.50
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>		<b>0.00</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны эрхэм зорилго нь иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлсэн “ногоон, хүн төвтэй” хот, суурин газрыг хөгжүүлж, хүртээмжтэй барилга, орон сууц, инженерийн дэд бүтцээр хангахад оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлон, үйл ажиллагааны стратегийн зорилтыг дор дурдсанаар дэвшүүлсэн байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, салбарын эрх зүйн зохицуулалтын талаар зөвлөгөө өгөх, салбарын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын суурь судалгаа, статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх бодлого боловсруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагаар хангах;
- Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтыг боловсруулах, хот дахин төлөвлөлтийг хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалтыг боловсруулах, хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалтаар хангах, салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах талаар салбарын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил гүйлгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажилладаг байна.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны 2025 оны төлөвлөгөөг батлуулан Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу “Барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, яамны төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд, мөн төлөвлөгөөт бусаар 20 минутын хот хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн нэгтгэсэн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн боловсруулсан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны нийт хөрөнгө 2,189,922.2 сая төгрөг болж, өмнөх оноос 236,509.2 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,626,770.6</b>	<b>1,868,529.9</b>	<b>241,759.3</b>
Мөнгөн хөрөнгө	116,093.1	82,270.6	(33,822.5)
Авлага	77,713.3	89,469.6	11,752.3
Урьдчилгаа	5,245.7	3,406.8	(1,838.8)
Бараа материал	64,199.0	60,628.7	(3,570.4)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,363,519.5	1,632,754.2	269,234.7
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>326,642.3</b>	<b>321,392.3</b>	<b>(5,250.0)</b>
Урт хугацаат	3,111.3	3,130.5	19.1
Үндсэн хөрөнгө	323,531.0	318,261.8	(5,269.2)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,953,413.0</b>	<b>2,189,922.2</b>	<b>236,509.2</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>796,705.1</b>	<b>790,119.1</b>	<b>(6,586.0)</b>
Богино хугацаат өр төлбөр	237,908.7	226,617.9	(11,290.8)
Урт хугацаат өр төлбөр	558,796.4	563,501.2	4,704.8
<b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,156,707.9</b>	<b>1,399,803.1</b>	<b>243,095.2</b>
Засгийн газрын хувь оролцоо	1,156,707.9	1,399,803.1	243,095.2
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,953,413.0</b>	<b>2,189,922.2</b>	<b>236,509.2</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөр, авлага, засгийн газрын хувь оролцооны данс материаллаг өөрчлөлттэй байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 82,270.6 сая төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 33,822.5 сая төгрөг буюу 29.1 хувиар буурсан нь Төрийн сан дахь хөрөнгө оруулалтын барьцаа данснаас чанарын баталгаа болон хөрөнгө оруулалтын барьцааг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт, Бууралт ( )
Касст байгаа бэлэн мөнгө	6.1	4.5	(1.6)
Төгрөг	6.1	4.5	(1.6)
Банкинд байгаа бэлэн мөнгө	116,087.0	82,266.1	(33,820.9)
Төгрөг	113,271.9	79,515.6	(33,756.3)
Төрийн сангийн харилцах	61,167.0	32,168.5	(28,998.5)
Арилжааны банк дахь харилцах	52,104.9	47,347.1	(4,757.8)
Гадаад валют	2,815.1	2,750.5	(64.5)
Төрийн сангийн харилцах	2,755.4	2,688.1	(67.3)
Арилжааны банк дахь харилцах	59.7	62.4	2.8
<b>Дүн</b>	<b>116,093.1</b>	<b>82,270.6</b>	<b>(33,822.5)</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгийн өсөлт, бууралт дараах байдалтай байна. Тухайлбал:

- Хөрөнгө оруулалт, их засварын данс: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч 87 компаниудын чанарын баталгааны хугацаа дуусаж, чанарын баталгаа болон хөрөнгө оруулалтын барьцааны 28,923.5 сая төгрөгийг чөлөөлсөн;
- Төрийн орон сууцны корпораци ТӨХХК: Хөгжлийн банкнаас авсан бондын хүүгийн төлбөрт 9,692.3 сая төгрөгийг төлсөн;
- Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй мега төслийн хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай нүүрс тээврийн конвейрерийн систем, бутлуур болон автомашинд ачих системийн төсөлд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж 5,572.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Тайлант оны эцэст нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 39,129.2 сая төгрөг буюу 47.6 хувийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, 34,856.5 сая төгрөг буюу 42.4 хувийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, 7,630.1 сая төгрөг буюу 9.3 хувийг Төрийн орон сууцны корпораци ТӨХК, 576.9 сая төгрөг буюу 0.7 хувийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо, 77.7 сая төгрөг буюу 0.1 хувийг Цемент шохой ХХК эзэлж байна.

### Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 1,742.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ХББОСЯ улсын төсвөөс бус өөрийн орлогоор санхүүжигдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори 83.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Байгууллагын чиг үүргийн бус ажилд дотоод албан томилолт, ажил мэргэжлийн харьяалалгүй, гадны хүмүүст гадаад албан томилолт, сургалт зохион байгуулах болон үзэсгэлэнд оролцохоор аяллын компанид, тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардалд төсвийн хөрөнгийг

- зарцуулсан /БННБС 177.4 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 95.8 сая төгрөг, ХСУХАТАҮЗХ 38.5 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 6.8 сая төгрөг, ХББОСЯ 3.4 сая төгрөг/;
- Анхан шатны баримт дутуу, баримтын иж бүрдлийн шаардлага хангаагүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр хөрөнгө зарцуулсан /ТОСК ТӨХХК 25.8 сая төгрөг, ХББОСЯ 10.7 сая төгрөг/
  - Цалин, нэмэгдэл, урамшууллыг илүү бодож олгосон / ХСУХАТАҮЗХ 205.1 сая төгрөг, Цемент шохой ХХК 15.3 сая төгрөг/;
  - Сахилгын шийтгэлтэй ажилтанд сургалтын төлбөр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн /Цемент шохой ХХК 56.3 сая төгрөг, ТОСК ТӨХХК 14.5 сая төгрөг/;
  - Гүйцэтгэх захирлын буруутай шийдвэрээр ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг төлсөн, бүтцийн өөрчлөлт нэрээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад тэтгэмж олгосон /Цемент шохой ХХК 315.6 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 121.7 сая төгрөг, ТОСК ТӨХХК 47.2 сая төгрөг/
  - 20 минутын хот хөгжлийн төв нь Засгийн газрын 2024 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 129, 238 дугаар тогтоолоор баталсан цалингийн жишгээс 124-262 хувь буюу 1.7-3.6 сая төгрөгөөр, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын суурь цалин/Ажлын хөлсний жишиг"-ээс 11-60 хувь буюу 0.5-1.5 сая төгрөгөөр илүү тогтоосон;
  - Сургалт, семинарыг цахимаар бус танхимаар зохион байгуулсан, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг хэтрүүлсэн, өөрсдийн гүйцэтгэх ажлаа гэрээгээр гүйцэтгүүлсэн; /ХСУХАТАҮЗХ 118.6 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 40.7 сая төгрөг, ХББОСЯ 6.2 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 3.9 сая төгрөг/
  - Хэмнэж болох зардлаас уулзалт, сэлбэг хэрэгсэл, засварын зардалд төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан; /ХСУХАТАҮЗХ 24.1 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 4.0 сая төгрөг, Цемент шохой ХХК 0.2 сая төгрөг, ХББОСЯ 0.1 сая төгрөг/
  - Хэвлэл мэдээллийн орон тооны ажилтантай боловч нэр бүхий 10 сайтуудтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан, "BIM"-ийн сургалт зохион байгуулсан, "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг зөрчсөн; /БННБС 168.6 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 59.6 сая төгрөг, ТОСК ТӨХХК 41.5 сая төгрөг/
  - Цемент шохой ХХК нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг хэрэглэлгүй худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн, тендер зохион байгуулалтын явц процессын алдаатай, үнэлгээний хороо холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллаагүй, үнэлгээний хороо тендерийг үнэлэхдээ 18 хоногийн дараа хуралдаж, шалгаруулсан, батлагдсан маягтын дагуу үнэлгээг шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан, худалдан авалтад шалгарсан оролцогчид гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй зэрэг 16,528.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

### 3.4.2 Авлага

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 89,469.6 сая төгрөг болж, өмнөх оноос 11,752.3 сая төгрөг буюу 15.1 хувиар нэмэгдсэн нь төрийн өмчит үйлдвэрийн газруудын дансны авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.0	0.4	(0.5)
Дансны авлага /ТӨҮГ/	56,042.5	68,033.4	11,990.8
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	112.5	1,445.1	1,332.7
Бусад авлага	21,557.3	21,557.3	(1,566.7)
Байгууллагаас авах авлага	20,872.1	19,976.7	(895.4)
Хувь хүмүүсээс авах авлага	685.2	13.9	(671.3)
<b>Дүн</b>	<b>77,717.3</b>	<b>89,469.6</b>	<b>11,752.3</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд авлагыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын хөрөнгө оруулалт, их завсар 68.9 хувь, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо 51.5 хувиар бууруулж, Цемент шохой ХХК 38.7 хувь, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 29.4 хувь, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК 0.8 хувиар авлага нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Цемент шохой ХХК бүтээгдэхүүн борлуулалтаас үүссэн 8 харилцагчийн 10,667.5 сая төгрөгийн авлагыг бүртгэсэн;
- БХТ ТӨААТҮГ Голомт банкинд байршуулсан 6,000.0 сая төгрөгийн хугацаатай хадгаламжаас 798.5 сая төгрөгийн хүүгийн авлагыг бүртгэсэн;
- ТОСК ТӨХХК түрээсийн орон сууцны түрээслэгчдээс авах төлбөр хугацаандаа бүрэн төвлөрүүлээгүй;
- ХББОСЯ хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 3,771.8 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн нь авлага нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

ХББОСЯ Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 1 дүгээр албан даалгавраар орлогод нийцсэн, өртөг багатай орон сууцны нийлүүлэлтийг орон нутагт нэмэгдүүлэх зорилгоор загвар туршилтын орон сууцыг ашиглалтад оруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 2024/277 дугаартай гэрээний 9,299.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг гүйцэтгэлээр бууруулан бүртгэсэн, ХСУХАТАҮЗХ Засгийн газрын 2000 оны 211 дүгээр тогтоолын хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас хуримтлагдсан авлагуудыг барагдуулсан байна.

Тайлант оны эцэст нийт авлагын үлдэгдлийн 53,587.3 сая төгрөг буюу 57.2 хувийг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, 28,097.8 сая төгрөг буюу 30.0 хувийг Цемент шохой ХХК, 8,036.5 сая төгрөг буюу 8.6 хувийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, 3,210.6 сая төгрөг буюу 3.4 хувийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, 794.9 сая төгрөг буюу 0.8 хувийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны авлага эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт

Авлагын данстай холбоотой 57,801.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Харилцагч байгууллагуудтай авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй; /Цемент шохой ХХК 8,296.1 сая төгрөг, ТОСК ТӨХХК 402.8 сая төгрөг, ХСУХАТАҮЗХ 13.5 сая төгрөг/
- Харилцагч байгууллагуудаас авах авлагыг барагдуулаагүй; /Цемент шохой ХХК 12,343.4 сая төгрөг/
- Найдваргүй авлагын нөөцийг тооцох суурь болон хувь хэмжээг бодит байдалд нийцүүлэлгүй байгуулсан /Цемент шохой ХХК 35,746.1 сая төгрөг/.

#### **3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгааны дансны эцсийн үлдэгдэл 3,406.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,838.8 сая төгрөгөөр буюу 35.1 хувиар буурсан нь тус яамны хөрөнгө оруулалт, их засварын дансны урьдчилж гарсан зардал буурсантай холбоотой байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Урьдчилж гарсан зардал	5,124.2	3,229.4	(1,894.8)
Урьдчилгаа тооцоо	121.5	177.4	55.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	121.5	177.4	55.9
<b>Дүн</b>	<b>5,245.7</b>	<b>3,406.8</b>	<b>(1,838.8)</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгааны дансны үлдэгдэл 3,406.8 сая төгрөг болж буурахад БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн гүйцэтгэлээр 1,157.9 сая төгрөгийг, Цемент шохой ХХК-ны Хөтөл 2 дугаар ордны түлшний савыг ашиглалтад оруулснаар 66.9 сая төгрөгийг, ХББОСС-ын 2024 оны 145 дугаар тушаалаар гурван хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээний гэрээт ажлууд тайлант онд хэрэгжсэнээр 39.8 сая төгрөгийг, 20 минутын хот хөгжлийн төв 2024 оны зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг дүгнэн 131.5 сая төгрөгийн зардлыг бууруулан бүртгэсэн байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 60,628.6 сая төгрөг болж, өмнөх оноос 3,570.4 сая төгрөг буюу 5.6 хувиар буурахад Цемент шохой ХХК-ийн бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгслийн зарцуулалт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Түүхий эд материал	6,356.1	7,445.3	1,089.2
Тусгай зориулалттай материал	6,356.1	7,445.3	1,089.2
Дуусаагүй үйлдвэрлэл	11,534.6	12,319.9	785.3
Бэлэн бүтээгдэхүүн	31,097.4	26,259.2	(4,838.1)
Хангамжийн материал	15,210.9	14,604.1	(606.8)
Бичиг хэргийн материал	17.0	19.6	2.7
Аж ахуйн материал	662.7	469.5	(193.2)
Сэлбэг хэрэгсэл	10,855.1	10,148.2	(706.9)
Түлш, шатах тослох материал	1,216.5	1,458.7	242.1
Барилгын засварын материал	290.7	304.6	13.8
Хүнсний материал	0.3	0.0	(0.3)
Бусад хангамжийн материал	2,168.6	2,203.6	35.0
<b>Дүн</b>	<b>64,199.0</b>	<b>60,628.6</b>	<b>(3,570.4)</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн хөрөнгийн өсөлт бууралт дараах байдалтай байна. Үүнд:

- Цемент шохой ХХК өөрийн хөрөнгөөр 203,140.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд 207,559.4 сая төгрөгийн материал зарцуулсан байна. Тайлант оны 8 дугаар сард чулуунцарын тээрмийн бул эвдэрч засвар хийж бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, сэлбэгийн материалаас 5,841.1 сая төгрөг, түүхий эд материал, шатах тослох материал, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 1,422.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан;
- ХББОСЯ төсвийн хөрөнгөөр 99.6 сая төгрөгийн материал худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд 97.8 сая төгрөгийн материал зарцуулсан бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар тус дансанд бүртгэлтэй байсан 10.7 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн, 6.1 сая төгрөгийн бараа материалыг акталсан;
- ТОСК ТӨХХК: Солонго-1, Солонго-2 төсөл, Залуус 1, Буянт Ухаа хороолол, Ховд, Хэнтий аймагт хэрэгжиж буй төслийн бэлтгэл ажилд 543.8 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийснээр бараа материал өссөн;
- БХТ ТӨААТҮГ өөрийн хөрөнгөөр 2,170,498.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 2,120,420.5 мянган төгрөгийн материал

зарцуулсан. Инженерийн энгэрийн тэмдгийг их хэмжээгээр худалдан авч нөөц үүсгэсэнтэй холбоотойгоор бараа материал нэмэгдсэн,

- ХСУХАТАҮЗХ өөрийн хөрөнгөөр 68.3 сая төгрөгийн түүхий эд, хангамжийн материал худалдан авч, 53.3 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэлд зарцуулсан байна.

Тодруулгын тайлангаар бараа материал худалдан авсан 207,482.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан 0.8 сая төгрөг, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 0.5 сая төгрөг, нийт 207,483.7 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаандаа зарцуулсан 211,036.5 сая төгрөг, шилжүүлсэн 11.5 сая төгрөг, бусад зарцуулалт 6.1 сая төгрөг, нийт 211,054.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бараа материал дансанд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК 800.0 сая төгрөг, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 50.1 сая төгрөг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо 15.0 сая төгрөгөөр тус тус өссөн, Цемент шохой ХХК 4,418.8 сая төгрөг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 15.0 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 1.6 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бараа материалын 43.3 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 24.1 хувийг хангамжийн материал, 20.3 хувийг дуусаагүй үйлдвэрлэл, 12.3 хувийг түүхий эд материалууд эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Бараа материалын данстай холбоотой 10,148.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Хэрэгцээнээс илүү барааг худалдан авч нөөцөлсөн /Цемент шохой ХХК 10,013.7 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 46.0 сая төгрөг/;
- Шатахууны тооцоо бодож, тайлан гаргаагүй /БХТ ТӨААТҮГ 49.2 сая төгрөг, ТОСК ТӨХХК 10.3 сая төгрөг, ХББОСЯ 2.5 сая төгрөг/;
- Бараа материал бодитоор оршин байхгүй /Цемент шохой ХХК 26.2 сая төгрөг/.

**3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,632,754.2 сая төгрөг болж, өмнөх оноос 269,234.7 сая төгрөг буюу 19.7 хувиар өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл 215,736.2 сая төгрөг, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн санхүүжилт, газар чөлөөлөлт, хяналтын зардалд 41,139.6 сая төгрөг, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл, “Солонго-1, Солонго-2” төслийн орон сууцны хорооллын дэд бүтцэд нийт 12,943.6 сая төгрөгийн ажлуудыг бүртгэсэн байна.

*Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,275,112.9	1,544,432.4	269,319.5
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	88,406.7	88,321.8	(84.8)
<b>Дүн</b>	<b>1,363,519.5</b>	<b>1,632,754.2</b>	<b>269,234.7</b>

*Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

**3.4.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны эцсийн үлдэгдэл 3,130.5 сая төгрөг болж өсөхөд Цемент шохой ХХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс төмөр замын техникийн

шаардлагын стандарт, аюулгүй байдлыг хангах, ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор худалдан авсан төмөр замын дэр модуудыг урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд бүртгэсэн байна.

Хүснэгт 7. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,111.3	3,130.5	19.1
<b>Дүн</b>	<b>3,111.3</b>	<b>3,130.5</b>	<b>19.1</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 318,261.8 сая төгрөг болж, өмнөх оноос 5,269.2 сая төгрөг буюу 1.6 хувиар буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Биет хөрөнгө	244,984.4	239,902.1	(5,082.3)
Барилга, байгууламж, орон сууц	132,565.7	130,150.3	(2,415.4)
Авто-тээврийн хэрэгсэл	7,888.3	9,915.0	2,026.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	92,421.1	87,904.4	(4,516.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,026.4	1,124.1	97.6
Бусад үндсэн хөрөнгө	1,396.0	1,054.5	(341.5)
Дуусаагүй барилга, байгууламж	9,668.1	9,735.1	67.0
Ном	18.7	18.7	0.0
Биет бус хөрөнгө	78,546.7	78,359.8	(186.9)
Программ хангамж	32.0	238.4	206.4
Бусад биет бус хөрөнгө	78,514.7	78,121.4	(393.2)
<b>Дүн</b>	<b>323,531.0</b>	<b>318,261.8</b>	<b>(5,269.2)</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт дараах байдалтай байна. Үүнд:

- ХСУХАТАҮЗХ аудитын зөвлөмжийн дагуу 670.9 сая төгрөгийн барилга байгууламжийг залруулсан, өөрийн хөрөнгөөр 248.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- БХТ ТӨААТҮГ өөрийн хөрөнгөөр 843.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ТӨБЗГ-ын 2024 оны 546, 730 дугаар тогтоолоор их засварын 682.1 сая төгрөгийг капиталжуулан бүртгэсэн, 2025 оны 224 дугаар тогтоолоор 185.8 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авсан;
- ТОСК ТӨХХК өөрийн хөрөнгөөр 99.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн;
- Цемент шохой ХХК шүүхийн шийдвэрээр 377.0 сая төгрөгийн орон сууцыг барилга, байгууламжийн дансанд бүртгэсэн, өөрийн хөрөнгөөр 3,620.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2,108.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг бэлтгэсэн, хөрөнгийн элэгдлийг 12,875.9 сая төгрөгөөр тооцсон;
- ХББОСЯ төсвийн хөрөнгөөр 26.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар 10.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын данснаас шилжүүлсэн бүртгэсэн, ТӨБЗГ-ын 2025 оны 396 дугаар тогтоолоор 106.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Тодруулгын тайлангаар төсвийн хөрөнгөөр 8,472.2 сая төгрөг, хандиваар 2.6 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 1,108.1 сая төгрөг, бусад хөрөнгө 359.9 сая төгрөг, нийт 9,942.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, акталсан 106.7 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 132.2 сая төгрөг, бусад хөрөнгө 403.8 сая төгрөг, нийт 642.7 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан. Тайлант онд 14,615.9 сая төгрөгийн хөрөнгийн элэгдлийг тооцож бүртгэсэн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 75.4 хувийг биет хөрөнгө, 24.6 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 33,658.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Хөрөнгийн ангилал, тоо хэмжээ зөрүүтэй, хөрөнгийн нэршлийг монгол хэлээр тусгаагүй, давхардуулан дугаарласан, бараа материалыг бүртгэсэн /Цемент шохой ХХК 14,688.3 сая төгрөг, 20 минутын хот хөгжлийн төв 160.7 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 60.1 сая төгрөг, ХББОСЯ 125,4 сая төгрөг/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэ, хугацааг шинэчлэн тогтоогоогүй /Цемент шохой ХХК 12,876.1 сая төгрөг, ТОСК ТӨХХК 416.8 сая төгрөг/
- Хөрөнгө эвдрэлтэй, ашиглагддаггүй, биетээр оршин байхгүй, өөр байгууллагад ашиглуулж байгаа /Цемент шохой ХХК 5,194.7 сая төгрөг, БННБС 136.2 сая төгрөг/;
- Цемент шохой ХХК-ийн хөрөнгийн бүртгэл, эмх цэгцгүй, эд хариуцагчийн картгүй, ашиглалт хадгалалт, хяналт сул, хөрөнгө бүрэн бүтэн бус, зарим эд анги сэлбэг тоногдсон зэрэг зөрчлүүд илэрсэн.

**3.4.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 790,119.1 сая төгрөг болж, өмнөх оноос 6,586.0 сая төгрөг буюу 0.8 хувиар буурсан нь богино хугацаат өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдлийн 226,617.9 сая төгрөг буюу 28.7 хувийг богино хугацаат өр төлбөр, 563,501.2 сая төгрөг буюу 71.3 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

Тайлант оны эцэст богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 226,617.9 сая төгрөгт хүрч, 11,290.8 сая төгрөгөөр буурахад байгууллагад төлөх өглөг, төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого, ТӨҮГ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгүүд голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 9. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Өглөг	199,610.9	178,351.2	(21,259.7)
Ажилчидтай холбогдсон өглөг	99.8	29.0	(70.9)
Зээлийн хүүгийн өглөг	23,569.3	29,219.5	5,650.2
Бусад өглөг	175,941.7	149,102.7	(26,839.1)
Байгууллагад төлөх өглөг	135,484.8	98,335.4	(37,149.3)
Хувь хүмүүст төлөх өглөг	6.2	37.1	30.9
Татварын өглөг /ТӨҮГ/	19,345.5	20,100.4	754.9
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,402.4	392.5	(2,009.9)
Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	17,070.5	17,070.5	0.0
Дансны өглөг /ТӨҮГ/	1,632.3	13,166.8	11,534.5
Урьдчилж орсон орлого	38,297.8	48,266.7	9,968.9
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,982.3	983.2	(999.0)
Бусад урьдчилж орсон орлого	36,315.6	47,283.5	10,967.9
<b>Дүн</b>	<b>237,908.7</b>	<b>226,617.9</b>	<b>(11,290.8)</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын богино хугацаат өр төлбөрийн өсөлт, бууралт дараах байдалтай байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниудын чанарын баталгаа болон хөрөнгө оруулалтын барьцааны 28,923.5 сая төгрөгийг чөлөөлсөн;
- Тус яамнаас хэрэгжүүлж буй “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн А1 багцын ерөнхий гүйцэтгэгч “Ludwig Pfeiffer-EMIT Group”-ийн гүйцэтгэлийн баталгаанаас 172.7 сая төгрөгийн зардал гарч, 105.5 сая төгрөгийн ханшийн зөрүүний бодит бус олзыг бүртгэсэн нь өглөг буурсан;
- Цемент шохой ХХК хуримтлагдсан татварын өр төлбөрийг 1,400.1 сая төгрөгийг барагдуулсан;
- ХСУХАТАҮЗХ Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын хүрээнд айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотойгоор Ус сувгийн удирдах газарт өгөх өглөгийг төлбөр төлөгдсөн дүнгээр бууруулсан;
- ТОСК ТӨХХК Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт барьж ашиглалтад оруулах иргэдийн орон сууцны барилга барихад олгосон Хөгжлийн банкны зээлийн хүүгийн өр 907.4 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- БХТ ТӨААТҮГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийн барилгын ажил бүрэн дуусаагүй, төслүүдийн зохиогчийн хяналт, зургийн зохиогч, экспертизийн ажлын төлбөрүүд бүрэн төлөгдөөгүйгээс 4,042.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд богино хугацаат өр төлбөрийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, хөрөнгө оруулалт, их завсар 43.7 хувь, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо 21.9 хувиар бууруулж, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК 70 дахин, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 13.6 хувиар өглөг нэмэгдсэн байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 563,501.2 сая төгрөгт хүрч 4,704.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д хэрэгжиж буй Засгийн газрын 2016 оны 38,169 дүгээр тогтоолын дагуу улсын төсвөөс олгосон зээлийн төлбөрийн өглөгийг 4,500.0 сая төгрөгөөр нэмэгдэж, орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд үүссэн өглөгийн хүүгийн төлбөр 1,176,0 сая төгрөг голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 10. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Урт хугацаат зээл	558,796.4	563,501.2	4,704.8
Төгрөг	558,796.4	563,501.2	4,704.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	26,681.9	27,857.9	1,176.0
Арилжааны банк	250,616.8	255,116.8	4,500.0
Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/	2,213.4	1,250.5	(962.9)
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	3,125.5	3,117.2	(8.4)
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	276,158.8	276,158.8	0.0
<b>Дүн</b>	<b>558,796.4</b>	<b>563,501.2</b>	<b>4,704.8</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

**Аудитын илрүүлэлт:**

Өр төлбөрийн данстай холбоотой 355,755.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Өглөгийн үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй /ТОСК ТӨХХК 379.0 сая төгрөг, БХТ ТӨААТҮГ 19.0 сая төгрөг/;
- Цемент шохой ХХК нь Хөгжлийн банканд төлөх өрийг 276,158.8 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг 41,916.8 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Цемент шохой ХХК өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, өглөгийн тайланд тусгагдсан 574 харилцагчтай холбоотой 20,909.7 сая төгрөгийн өр, 16,372.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

### 3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцооны дансны эцсийн үлдэгдэл 1,399,803.1 сая төгрөг болж, өмнөх оноос 243,095.2 сая төгрөг буюу 21.0 хувиар нэмэгдсэн нь тайланд оны үр дүнгийн 254,110.9 сая төгрөг голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, Бууралт ( )
Засгийн газрын хувь оролцоо	1,156,707.9	1,399,803.1	243,095.2
Засгийн газрын оруулсан капитал	412.4	412.4	0.0
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	412.4	412.4	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	11,953.5	11,953.5	0.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	212.5	212.5	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	73,152.9	73,182.9	30.0
Хуримтлагдсан үр дүн	1,022,210.1	1,265,346.8	243,136.7
Өмнөх үеийн үр дүн	635,324.5	1,011,235.9	375,911.4
Тайлант үеийн үр дүн	386,885.6	254,110.9	(132,774.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48,766.5	48,695.0	(71.5)
<b>Дүн</b>	<b>1,156,707.9</b>	<b>1,399,803.1</b>	<b>243,095.2</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалт, их засварын дансны 271,393.0 сая төгрөг, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 4,011.2 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүн нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд нийт зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,401,170.4 сая төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 12,811.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 188.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 970,608.1 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 47,800.0 сая төгрөг, нийт 1,031,407.7 сая төгрөгөөр бууруулж, татаасыг 63,150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 432,912.7 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, анх баталсан төсвийг 21,951.3 сая төгрөгөөр бууруулж, 410,961.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Энэ нь Төрийн

хэмнэлтийн хуульд заасны дагуу гэрээ байгуулагдаагүй төсөл, арга хэмжээг бүхэлд нь хассан, гэрээ байгуулсан дүнгийн зөрүүгээр төсөвт өртгийг бууруулсан мөн тайлант оны батлагдсан төсөл арга хэмжээнүүдийн санхүүжих дүнг өөрчилсөнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсныг цалин хөлсний нэмэгдэл, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, урсгал засвар, тэтгэмж урамшууллын зардал хүрэлцэхгүйгээс шалтгаалан тайлант хугацаанд зарлагын эдийн засгийн ангилал хооронд 3 удаа, нийт 259.9 сая төгрөгийн зарлагын зохицуулалтыг хийсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 410,961.4 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний зардалд 7,162.4 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 44,083.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 215,732.0 сая төгрөг, дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрт 4,500.0 сая төгрөгийг шилжүүлэн, зарцуулаагүй 722.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 271,477.8 сая төгрөг буюу 66.1 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал зардлын төсвийг 1,021.1 сая төгрөг, урсгал шилжүүлгийг 58.2 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 119,040.4 сая төгрөг, татаасыг 19,363.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71502	Хот байгуулалт, тохижилт	2,801.0	2,166.5	634.5	77.3
71509	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй	408,160.5	268,434.3	139,726.1	65.8
71105	Авто тээврийн хяналт, зохицуулалт	0.0	877.0	(877.0)	0.0
	<b>Нийт зардал</b>	<b>410,961.4</b>	<b>271,477.8</b>	<b>139,483.6</b>	<b>66.1</b>

Батлагдсан нийт төсвийн гүйцэтгэлийн 98.9 хувийг барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлт, 0.8 хувийг хот байгуулалт, тохижилт, 0.3 хувийг авто тээврийн хяналт, зохицуулалт хөтөлбөрүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Зориулалт болон арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	7,489.2	6,779.6	709.6	90.5
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	204.1	202.1	2.0	99.0
80404 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,861.4	43,497.5	19,363.9	69.2
80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж	314.8	304.0	10.8	96.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	329.3	281.9	47.4	85.6
80918 Бусад	334,772.4	215,732.0	119,040.4	64.4
81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	490.2	180.7	309.5	36.9
83117 Орон сууцжуулах	4,500.0	4,500.0	0.0	100.0
	<b>410,961.4</b>	<b>271,477.8</b>	<b>139,483.6</b>	<b>66.1</b>

Эх сурвалж: ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант хугацааны тус ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалтын талаарх судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орон тоог 9.0 хувиар бууруулж, баталснаар тус яам 99 орон тоог 9-ээр, 20 минут хот хөгжлийн төв 35 орон тоог 3-аар, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 273 орон тоог 51-ээр тус тус цомхотгосон байна. Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын цалингийн санг 11,407.2 сая төгрөгөөр баталснаас 95.5 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллагууд нь ажлын нэг өдрийн хоолны зардлыг 1,000-10,000 төгрөгөөр, 5,000-34,000 төгрөгөөр, унааны зардлыг 1,000-10,000 төгрөгөөр тус тус тогтоож, тайлант хугацаанд хоолны зардалд 2,254.5 сая төгрөг, унааны зардалд 128.8 сая төгрөг, нийт 2,383.3 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр хоолны зардалд 2,259.5 сая төгрөг, унааны зардалд 118.3 сая төгрөг, нийт 2,376.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллага гадаад албан томилолтод 705.9 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 46 төсөл, арга хэмжээнд 310.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Барилгын хөгжлийн төв ТӨААТҮ нийт зарцуулалтын 65.0 хувийг эзэлж байна.

4. Сургалт, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын сургалтад 591.2 сая төгрөг, хурал, зөвлөгөөнд 227.5 сая төгрөг, нийт 818.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: сургалтаас барилгын мэргэжлийн чиглэлээр 345.1 сая төгрөг, санхүү, мэдээлэл технологи, хууль эрхзүйн чиглэлээр 93.5 сая төгрөг, хувь албан хаагчид чиглэсэн 72.9 сая төгрөг, бусад чиглэлээр 18.1 сая төгрөгийг; зөвлөгөөнд 124.2 сая төгрөг, хэлэлцүүлэгт 103.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн талаар:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага хэвлэл мэдээллийн 46 байгууллагуудтай нийт 281.1 сая төгрөгийн ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 252.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардлын талаар:

Удирдлагын буруу шийдвэрээр 2024-2025 онуудад ажлаас халагдсан 2 байгууллагын 2 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагын төсвөөс 680.0 сая төгрөгийг олгосон байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц сангаас 872.0 сая төгрөг, Герман улсын Пфайфер, Эмит компаний гүйцэтгэлийн баталгааны хөрөнгийн валютын данснаас 172.4 сая төгрөг, нийт 1,045.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөл хэрэгжүүлэгч Бэрэн групп ХХК болон Цагаан хуаран консалтинг ХХК-тай холбоотой “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний зээлийн эргэн төлөлтийн маргаан шийдвэрлэх арбитрын ажиллагааны зардалд 872.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлаар, Пфайфер компаниас импортолсон тоног төхөөрөмжүүдийн гаалийн бүрдүүлэлт, татварын зардалд 172.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулж, зарцуулагдаагүй 0.6 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэн, Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлсэн байна.

Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
81101 Засгийн газрын нөөц хөрөнгө	1,045.5	1,044.9	0.6	99.9
<b>Дүн</b>	<b>1,045.5</b>	<b>1,044.9</b>	<b>0.6</b>	<b>99.9</b>

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан төсвийн хөрөнгөөр байгууллагын бусад үйл ажиллагааг хангахад нийт 163,462.5 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг нийлүүлснээс шууд худалдан авах аргаар бичиг хэргийн зардалд 52,837.4 мянган төгрөг, тавилга, эд хогшил, ерөөний засварт 46,370.4 мянган төгрөг, шатахуун сэлбэг хэрэгсэлд 16,110.9 мянган төгрөгийг, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад 96,779.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 4 багц төсөл батлагдсаны дагуу 2025 оны 20, 21 дүгээр тушаалаар нэгтгэл, 46 дугаар тушаалаар дэлгэрэнгүй жагсаалтаар батлагдсан.

Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоол, ХББОССайдын 2025 оны 24, 25, 45, 92, 93 дугаар тушаалуудын дагуу “Шинэ хархорум” хотын эхний ээлжийн барилгажилтын төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээ, нэвтрэх хонгилын систем, 2 дугаар ээлжийн инженерийн шугам сүлжээ авто замын зураг төслийн задаргааны долоон ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн худалдан авах ажиллагааны газарт, Сүхбаатар, Ховд, Дархан-Уул, Увс, Сэлэнгэ, Хэнтий, Булган зэрэг аймгуудад хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний ажлуудын эрхийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчдад тус тус шилжүүлсэн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд бүсүүдэд хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний 19 төсөл, арга хэмжээ, төрийн албан хаагчдын 8,15 айлын орон сууцжуулах төслийн 19, нийт 38 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, төсөл, арга хэмжээний 29 ажилд гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилт 76.1 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувьд тус яамны сайдын багцын нийт 57 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь зохион байгуулж, төсөл, арга хэмжээний 40 гэрээг байгуулсан бөгөөд гэрээний биелэлт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

### 3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 4 хөтөлбөрийн хүрээнд 10 арга

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хэмжээний зорилтот түвшнийг тусгасан ба хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн нь 74.0 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

Хүснэгт 15. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт /сая төгрөгөөр/

№	Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн нэр	2025 оны зорилтот түвшин	2025 оны хүрсэн түвшин	Нийт төсөв	Гүйцэтгэл	
<b>Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага</b>						
34	34.1.1.1	Улсын Их хурал болон Засгийн газраар батлуулах барилга, хот байгуулалтын салбарын холбогдох дүрэм, журам	3	3	250,406.8	175,500.7
	34.1.2.1	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ	50 км	97.2 км		
	34.1.2.2	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ	50 км	57.3 км		
	34.1.3.1	Шинээр барих цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын явц	60 хувь	67 хувь		
	34.1.4.1	Барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдал	15 хувь	15 хувь		
	34.1.5.1	Үндэсний орон сууцны хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл	1 төсөл	50 хувь		
	34.1.5.2	Түрээсийн орон сууцны нэг маягийн зураг төсөл	4			
	34.1.5.3	Төрийн албан хаагчдын орон сууцны барилгын нэг маягийн зураг төсөл	2	12		
<b>Хот суурингийн ерөнхий төлөвлөлт</b>						
34	34.2.1	"Шинэ Хархорум" хотын 2 дугаар ээлжийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл	50 хувь	80.5 хувь	250,406.8	175,500.7
	34.2.2	Нийслэл Улаанбаатар хотын дагуул хотуудын бүтээн байгуулалт	10 хувь	10 хувь		
<b>Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр</b>						
34	34.3.1	Зорчилтын судалгаа	100 хувь	100 хувь	250,406.8	175,500.7
	34.3.2	Тандан судалгаа	100 хувь	100 хувь		
	34.3.2.1	Төхөөрөмж, хэрэглүүр нийлүүлэлтийн биелэлт	100 хувь	100 хувь		
	34.3.2.2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуульд зохион байгуулах	200 удаа	-		
	34.3.2.3	Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах	300	-		
<b>Төрийн нийтлэг бусад үйлчилгээний судалгаа шинжилгээ</b>						
34	34.4.1.1	Бодлогын бичиг баримт	2	-	250,406.8	175,500.7
	34.4.1.2	Дүрэм, журам	2	-		

**Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлагын хүрээнд:**

34.1.1.1 Засгийн газрын 2025 оны “1008 айлын орон сууцны төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол, “Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй

байдлын техникийн зохицуулалтыг батлах тухай” 210 дугаар тогтоол, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг батлах тухай” 211 дүгээр тогтоол батлагдсан байна.

34.1.2 Жилийн эцсийн байдлаар нийт 97.16 км цэвэр усны шугам сүлжээ, 57.34 км бохир усны шугам сүлжээний барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн байна.

34.1.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын 6 сум болон Багануур дүүрэгт ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн нийт 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд гүйцэтгэл 67.1 хувьтай байна.

34.1.4.1 Улсын хэмжээнд нийт 155 иргэн, 870 аж ахуйн нэгж, байгууллагын 1025 барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулан, нийт 4595 зөрчил илрүүлснээс 2552 зөрчлийг арилгуулсан, хяналт шалгалтын хүрээнд улсын байцаагчийн 170 албан шаардлага, 50 акт, 127 дүгнэлт, 259 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулсан, 731,550.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 60 барилга байгууламж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүрэн зогсоосон байна.

34.1.5.1 “Үндэсний орон сууцжуулалтын тухай” хуулийн төслийг боловсруулах явцад Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 45 дугаар захирамжийн дагуу иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Орон сууцжуулалтын тухай” хууль болон “Орон сууцны санхүүжилтийн банкны тухай” хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан, холбогдох судалгаа, шинжилгээг хийгдэж байна.

34.1.5.3 “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-ийн хүрээнд орон нутагт мэргэжлээрээ ажиллаж, амьдрах төрийн албан хаагчдад зориулсан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, ногоон барилгын шаардлагыг хангасан орон сууцны загвар зураг төслүүдийг боловсруулан, хэсэгчилсэн шийдлээр төлөвлөн 2024–2025 онд аймаг, сумдын Засаг дарга нартай хамтран 12 байршилд хэрэгжүүлж, 12 барилгын зураг төсөл магадлалын дүгнэлтээр баталгаажсан байна.

#### **Хот суурингийн ерөнхий төлөвлөлтийн хүрээнд:**

34.2.1 “Шинэ Хархорум” хотын II ээлжийн авто зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл 70.0 хувь, инженерийн нарийвчилсан зураг төсөл 70.0 хувь, “Хэлтгий цагаан” нуурыг сэргээх, бохирдолт болон ширгэлтээс хамгаалах судалгаа, зураг төсөл 90.0 хувь, Хархорум хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэр нэгдүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг болон холбогдох барилга байгууламжийн зураг төсөл 85.0 хувь, Арвайхээр-Хархорум хот чиглэлийн 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төсөл 77.0 хувь, нийт ажлын 80.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

34.2.2 Шинэ Зуунмод хотын 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ ‘Аэросити’ дэд станцын барилга угсралтын ажлын үргэлжлэл, “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл хэрэгжиж байгаа, Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй “Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадвартай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төслийн техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт” гарсан.

#### **Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээврийн хүрээнд:**

34.3.2 “20 минутын хот-Үндэсний хороо”-ны үед Улаанбаатар хотын авто замын түгжрэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн зорчилд болон тандан судалгааг хийсэн.

Хиймэл оюунд суурилсан системийг ашиглан замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх, зөрчлийн хэргийг автоматжуулсан систем, цахим хэлбэрээр бүртгэх, шалгах, хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсч, “Зөрчлийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн, батлуулсан байна.

**Төрийн нийтлэг үйлчилгээ, судалгаа шинжилгээний хүрээнд:**

34.4.1 Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 22 дугаар тогтоолоор “20 минутын хот-Үндэсний хороо”-г татан буулгаж, чиг үүргийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад харьяалагдах “20 минутын хот хөгжлийн төв”-д шилжүүлсэн бөгөөд “20 минутын хот” үзэл баримтлалыг хэрэгжүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хотын орон зайн тэнцвэртэй хөгжлийг хангах, тогтвортой хотын хөгжлийг дэмжихэд чиглэн ажилладаг байгууллага байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдсэн ТЕЗ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн барилгын норм, норматив, дүрмийг боловсруулах, зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 03/1193 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 78,172.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 781.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тогтоосон шалгуур үзүүлэлтийг үндэслэн тухайн шалгагдагч байгууллагуудад хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, тэтгэмж, нөхөн төлбөр, томилолт, сургалт, тэмцээн, түрээсийн зарцуулалттай холбоотой 425.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 21.7 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 1,267.5 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, 69.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны цахим хуудсанд 9,150.5 сая төгрөгийн орлого, зарлагын 119 ажил гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроосон, 331.4 сая төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг ил тод байршуулахаас зайлсхийж, төлбөрийг таван сая төгрөгт хүргэлгүй хэсэгчлэн хувааж, гүйлгээг хийсэн зөрчлийг давтан гаргасан зэрэг нийт 9,481.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,482.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 6,999.6 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Бусад нийцлийн асуудлаар 15,314.3 сая төгрөгийн зөрчлүүдээс 8,250.0 сая төгрөгийн 13 албан шаардлага, 6,999.6 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 64.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн зарим заалттай, бусад нийцлийн асуудал нь зарим хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 16. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	951.8	1	951.8	100.0
Албан шаардлага	1	45,078.3	0	0.0	00.0
Зөвлөмж	1	87,226.4	0	84,719.2	97.1
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>132,304.7</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>65.7</b>

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг 2025 оны аудитаар илэрсэн зөрчлүүдтэй харьцуулахад нэмэгдсэн, авлага бууруулах зөвлөмж хэрэгжээгүй тул цаашид дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны Цемент шохой ХХК-ий талаар авах арга хэмжээний тухай" 258 дугаар тогтоолоор тус ТӨХК-ийг "Эрдэнэс монгол" ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар тогтоосон байхад тус аж ахуйн нэгжийг Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамааруулж, санхүүгийн тайланг нэгтгэсэн;
- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Замын үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл" 2017 онд, "Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл" 2018 онд хэрэгжиж дууссан боловч хөрөнгийг бүрэн хүлээлгэж өгөөгүй, 1,017.5 сая төгрөгийн хөрөнгө биетээр байхгүй, 190.5 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй, мөн 1,559.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтын явцад маргаан үүссэн, төслийн төсөвт өртөгт анхнаасаа тусгагдаагүй тоног төхөөрөмжийг шаардсан зэрэг шалтгаанаар өнөөдрийг хүртэл хаалтын баланс гаргаж эцэслээгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 48,414.7 сая төгрөгийн алдаа илэрснээс 1,130.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, залруулаагүй 47,284.7 сая төгрөгийн алдаанд 1 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн асуудлаар нийт 557,497.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 65.7 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47,471.5 сая төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцох албан шаардлага, 107,297.0 сая төгрөгийн зөрчилд 47 албан шаардлага хүргүүлж, 402,663.0 сая төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өгсөн байна.

Нийт залруулагдаагүй 557,584.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 556,802.9 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 1 байгууллагад /Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам -ТШЗ/ “Өөрчлөлтгүй”, 3 байгууллагад /Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, Төрийн орон сууцны корпорацн ТӨХХК, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо/ “Хязгаарлалттай”, 1 байгууллагад (Цемент шохой ХХК) “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар санхүүгийн асуудлаар 7,984.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж өглөө.

#### 5.2.1 Албан шаардлага

1. ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналт хангалтгүйгээс 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5 байгууллагад дүгнэлт өгснөөс 1 байгууллага Сөрөг дүгнэлт авсан, санхүүгийн асуудлаар 549,512,730,199.00 /Таван зуун дөчин есөн тэрбум таван зуун арван хоёр сая долоон зуун гучин мянга нэг зуун ерэн ес/ төгрөгийн зөрчил илэрснээс 65,707,530.00 /Жаран таван сая долоон зуун долоон мянга таван зуун гуч/ төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47,471,529,817.00 /Дөчин долоон тэрбум дөрвөн зуун далан нэгэн сая таван зуун хорин есөн мянга найман зуун арван долоо/ төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцох албан шаардлага, 99,312,488,594.00 /Ерэн есөн тэрбум гурван зуун арван хоёр сая дөрвөн зуун наян найман мянга таван зуун ерэн дөрөв/ төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага хүргүүлж, 402,663,004,258.00 /Дөрвөн зуун хоёр тэрбум зургаан зуун жаран гурван сая дөрвөн мянга хоёр зуун тавин найм/ төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өгч, 2 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Мөн бусад нийцлийн асуудлаар 15,314,315,999.00 /Арван таван тэрбум гурван зуун арван дөрвөн сая гурван зуун арван таван мянга есөн зуун ерэн ес/ төгрөгийн зөрчил илэрсэнд 13 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн

5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлага өмнөх оноос 7,984,485,737.93 /Долоон тэрбум есөн зуун наян дөрвөн сая дөрвөн зуун наян таван мянга долоон зуун гучин долоон төгрөг ерэн гурван мөнгө/ төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын авлага өмнөх оноос нэмэгдсэн зөрчлийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа "20 минутын хот хөгжлийн төв" нь төсвийн шууд захирагчийн статустай бөгөөд албан хаагчдын цалин нь Засгийн газрын тогтоолоор баталсан Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн жишгээс 1.7-3.6 сая төгрөгөөр илүү тогтоосон. Тайлант онд гүйцэтгэсэн 21 ажлаас 20 ажил нь хотын захирагчийн, 1 ажил нь зам тээврийн яамны чиг үүрэгтэй холбоотой ажлыг гүйцэтгэсэн нь үзэл баримтлал, бодлогын бичиг баримтыг боловсруулах үндсэн чиг үүрэгтэй нийцээгүй бөгөөд тус яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогын газрын чиг үүрэгтэй давхцаж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 2-т "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "20 минутын хот хөгжлийн төв"-ийн албан хаагчдын цалин хөлсийг тогтооходоо төрийн албаны зарим албан тушаалын цалингийн жишгийг баримталж, бүтцийг оновчтой тодорхойлж, чиг үүргийн давхардлыг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

## 5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг”-ийг /норм, норматив, дүрэм/ жил бүр шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэн салбарын хороо, зөвлөл, хурлаар хэлэлцүүлэн баталдаг. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй 2018-2022 онд байгуулсан нийт 1,377.0 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагууд хэрэгжихгүй үр дүн гарахгүй байна. Дээрх ажлын үр дүн гүйцэтгэл хангалтгүй байгаа нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг гүйцэтгэхэд баримтлах баримт бичгийг сайжруулах, барилгын чанар, аюулгүй байдлыг хангахад чухал үүргийг гүйцэтгэх салбарын судалгаа шинжилгээний мэргэжлийн байгууллага байхгүйгээс боловсруулсан норм, дүрэм судалгаа, шинжилгээ хангалтгүй байгаа нь нөлөөлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 47 дугаар зүйлийн 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Барилгын норм, норматив, дүрмийг чанартай боловсруулах, зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналтыг сайжруулах арга хэмжээ авах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын харьяа байгууллагууд</b>													
1	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК	3	171.4	1	13.5	2	157.8	2	171.4				
2	Хот суурины Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	1	220.0			1	220.0	1	220.0				
3	Цемент шохой ХХК	4	48,023.4	3	48,009.0	1	14.3	3	738.7	1	47,284.7	1	47,284.7
<b>Нийт дүн</b>		<b>8</b>	<b>48,414.7</b>	<b>4</b>	<b>48,022.6</b>	<b>4</b>	<b>392.2</b>	<b>6</b>	<b>1,130.0</b>	<b>1</b>	<b>47,284.7</b>	<b>1</b>	<b>47,284.7</b>

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудал											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох АШ		Хуулийн байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	5	7,984.5			3	7,984.5	2	0.0				
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>7,984.5</b>			<b>3</b>	<b>7,984.5</b>	<b>2</b>	<b>0.0</b>				
1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам ТШЗ	7	232.3	1	0.9	4	103.6	2	127.8				
2	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	7	333.7			6	273.6	1	60.1				
3	Барилгын норм норматив боловсруулах сан ТӨҮГ	6	482.1			5	482.1	1	0.0				
4	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК	10	23,883.7	1	14.5	6	21,659.9	2	427.5	1	1,781.8		
5	Цемент шохой ХХК	29	511,041.8	5	48.2	9	63,541.5	10	401,762.4	3	45,689.7	2	514,889.1

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо	9	399.9	2	2.1	5	328.4	2	69.4				
7	20 минутын хот хөгжлийн төв ТШЗ	10	554.0			7	338.2	3	215.8				
8	Замын үүдийн дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргаа ТХН	1	1,208.0			1	1,208.0						
9	Дэд бүтэц 7,14 төсөл ТХН	1	11,377.2			1	11,377.2						
<b>Дүн</b>		<b>80</b>	<b>549,512.7</b>	<b>9</b>	<b>65.7</b>	<b>44</b>	<b>99,312.5</b>	<b>21</b>	<b>402,663.0</b>	<b>4</b>	<b>47,471.5</b>	<b>2</b>	<b>514,889.1</b>
<b>Нийт дүн</b>		<b>85</b>	<b>557,497.2</b>	<b>9</b>	<b>65.7</b>	<b>47</b>	<b>107,297.0</b>	<b>23</b>	<b>402,663.0</b>	<b>4</b>	<b>47,471.5</b>	<b>2</b>	<b>514,889.1</b>

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа							
		Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын харьяа байгууллагууд</b>									
1	Барилгын норм нормативын сан	2	331.5	2	331.5				
2	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	1	86.0	1	86.0				
3	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК	2	334.7	1	269.9	1	64.8		
4	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо	1	513.6	1	513.6				
5	Цемент шохой ХХК	10	12,411.2	7	5,411.6	2	0.0	1	6,999.6
6	20 минутын хот хөгжлийн төв	1	1,637.3	1	1,637.3				
<b>Дүн</b>		<b>17</b>	<b>15,314.3</b>	<b>13</b>	<b>8,250.0</b>	<b>3</b>	<b>64.8</b>	<b>1</b>	<b>6,999.6</b>
<b>Нийт дүн</b>		<b>19</b>	<b>15,314.3</b>	<b>14</b>	<b>8,250.0</b>	<b>4</b>	<b>64.8</b>	<b>1</b>	<b>6,999.6</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1403/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026 /23/ ИА -СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлага өмнөх оноос 7,984,485,737.93 /Долоон тэрбум есөн зуун наян дөрвөн сая дөрвөн зуун наян таван мянга долоон зуун гучин долоон төгрөг ерэн гурван мөнгө/ төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын авлага өмнөх оноос нэмэгдсэн зөрчлийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /Э.Бат-Амгалан/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Уянга/, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Найрамдал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

 С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1404/АО111371

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналт хангалтгүйгээс 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5 байгууллагад дүгнэлт өгснөөс 1 байгууллага Сөрөг дүгнэлт авсан, санхүүгийн асуудлаар 549,512,730,199.00 /Таван зуун дөчин есөн тэрбум таван зуун арван хоёр сая долоон зуун гучин мянга нэг зуун ерэн ес/ төгрөгийн зөрчил илэрснээс 65,707,530.00 /Жаран таван сая долоон зуун долоон мянга таван зуун гуч/ төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47,471,529,817.00 /Дөчин долоон тэрбум дөрвөн зуун далан нэгэн сая таван зуун хорин есөн мянга найман зуун арван долоо/ төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцох албан шаардлага, 99,312,488,594.00 /Ерэн есөн тэрбум гурван зуун арван хоёр сая дөрвөн зуун наян найман мянга таван зуун ерэн дөрөв/ төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага хүргүүлж, 402,663,004,258.00 /Дөрвөн зуун хоёр тэрбум зургаан зуун жаран гурван сая дөрвөн мянга хоёр зуун тавин найм/ төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өгч, 2 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Мөн бусад нийцлийн асуудлаар 15,314,315,999.00 /Арван таван тэрбум гурван зуун арван дөрвөн сая гурван зуун арван таван мянга есөн зуун ерэн ес/ төгрөгийн зөрчил илэрсэнд 13 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж,

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\424 САГ-40.1.docx

1526182413

гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /Э.Бат-Амгалан/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Уянга/, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Найрамдал/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1405/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026 /23/НА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа “20 минутын хот хөгжлийн төв” нь төсвийн шууд захирагчийн статустай бөгөөд албан хаагчдын цалин нь Засгийн газрын тогтоолоор баталсан Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн жишгээс 1.7-3.6 сая төгрөгөөр илүү тогтоосон. Тайлант онд гүйцэтгэсэн 21 ажлаас 20 ажил нь хотын захирагчийн, 1 ажил нь зам тээврийн яамны чиг үүрэгтэй холбоотой ажлыг гүйцэтгэсэн нь үзэл баримтлал, бодлогын бичиг баримтыг боловсруулах үндсэн чиг үүрэгтэй нийцээгүй бөгөөд тус яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогын газрын чиг үүрэгтэй давхцаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл “Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 2-т “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. “20 минутын хот хөгжлийн төв”-ийн албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо төрийн албаны зарим албан тушаалын цалингийн жишгийг мөрдөж, бүтцийг оновчтой тодорхойлж, чиг үүргийн давхардлыг арилгаж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /Э.Бат-Амгалан/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Уянга/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



СМ

С.МАГНАЙСҮРЭН